

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.11.24

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Эдийн засгийн тайлангууд хойшлогдож байгаа нь зах зээл дээр хоёрдмол байдлыг үүсгэж байна.
- ХНС 12-р сард хүүг бууруулах магадлал нэмэгдлээ.
- Nvidia-н тайлан сайн гарсан ч зах зээл дээр болгоомжлол хэвээр байна.
- Nvidia-руу бүтээгдэхүүн нийлүүлэгч компаниудын хувьцаа өслөө.
- Хятад улс үл хөдлөхийн салбарын уналтыг зөөлрүүлэх шинэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлээ.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Эдийн засгийн тайлан мэдээнүүд гарч, тогтворжих хүртэл АНУ-ын зах зээл дээр чиглэлгүй байдал үргэлжлэх магадлалтай.

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна

Golomt_Capital created with TradingView.com, Nov 24, 2025 11:38 UTC+8

US 500 Index - 1D - Pepperstone O6,651.5 H6,651.8 L6,623.0 C6,640.8 +27.0 (+0.41%) +27.1 (+0.41%)
Vol 23.33K





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.11.17-11.23

NVIDIA-Н ТАЙЛАН САЙН ГАРСАН Ч БОЛГООМЖЛОЛ ХЭВЭЭР БАЙНА

Энэ улирлын хамгийн их хүлээлттэй байсан тайланг NVIDIA танилцууллаа. S&P 500 индексийн хамгийн өндөр үнэлгээтэй компани болсон тус чип үйлдвэрлэгч компани 3-р улиралд орлогоо дээд цэгт хүргэж, шинжээчдийн таамгийг давсан байна. Үүний гол шалтгаан нь хиймэл оюун ухаанд ашиглагддаг NVIDIA-гийн өндөр чадлын чипүүдийн эрэлт маш өндөр байгаа нь юм. Мөн компани 4-р улирлын орлогын таамгаа олон нийтийн хүлээлтээс илүү өндөр гаргаж, зах зээлд эерэг дохио өглөө.

Эхэндээ энэ мэдээ хөрөнгийн зах зээлд сайн нөлөө үзүүлж, пүрэв гарагийн өглөө арилжаа эхлэхэд NVIDIA-ийн хувьцаа өсөж эхэлсэн. Гэвч өглөөний арилжааны дунд үеэс хандлага огцом өөрчлөгдөж, компанийн хувьцаа өдрийн эцэст 3%-иар унасан юм. Энэ уналт нь зах зээлийн гол индексүүдийг ч бас доош нь чирсэн. Мэдээж NVIDIA тайлан гарахаас өмнө хэд хоног зах зээлийг дарамталж байсан хиймэл оюуны салбарын болгоомжлол дахин хүчтэй болсон билээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ТАЙЛАНГУУД ХОЙШИЛЖ БАЙГАА НЬ ХОЁРДОМЛ БАЙДЛЫГ ҮҮСГЭСЭЭР

Засгийн газрын урт хугацааны зогсолтоос болж зургаан долоо хоногийн турш хойшлогдоод байсан АНУ-ын Хөдөлмөрийн яамны 9-р сарын хөдөлмөрийн зах зээлийн тайлан пүрэв гарагт эцэст нь нийтлэгдлээ. Уг тайлан эдийн засгийн төлөв байдал тодорхой хэмжээнд сайжирч байгаа ч бүрэн өөдрөг дүр зураг хараахан бий болоогүйг харуулж байна.

Тайланд дурдсанаар, АНУ-ын ажил олгогчид есдүгээр сард 119,000 шинэ ажлын байр нэмсэн нь шинжээчдийн хүлээлтээс илт өндөр үзүүлэлт бөгөөд зуны турш бараг зогссон байсан ажилд авах үйл явц сэргэж эхэлж буйг илтгэв. Гэхдээ эерэг мэдээнээс гадна санаа зовоох шинж тэмдэг ч байна. Ажилгүйдлийн түвшин 9-р сард 4.4% болж өссөн нь өнгөрсөн сарын 4.3%-тай харьцуулахад нэмэгдэж, сүүлийн дөрвөн жилийн хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Энэ нь ажлын байр нэмэгдэж байгаа ч олон хүн ажил хайж байгаа боловч олж чадахгүй хэвээр байгааг харуулж байна.

Мөн Хөдөлмөрийн статистикийн дараагийн хөдөлмөрийн зах зээлийн тайлан болох 11 сарын мэдээллийг 12-р сарын 16-нд гаргана гэж мэдэгдэв. Харин засгийн газрын зогсолтоос үүдэн 10 сарын тайлан бүрмөсөн цуцлагдсан байна.

12-Р САРД ХҮҮГ БУУРУУЛАХ МАГАДЛАЛ ДАХИН НЭМЭГДЛЭЭ

Хөрөнгө оруулагчид ХНС 12-р сарын 9–10-нд хийх уулзалтаараа бодлогын хүүг дахин бууруулах эсэхэд анхаарлаа төвлөрүүлсээр байна. ХНС-ийн 10-р сарын хуралдааны тэмдэглэлд тус банкны шийдвэр гаргагчид одоохондоо дахин бууруулалт хийх шаардлагад нэлээд болгоомжтой, бүр эргэлзээтэй хандаж байгааг харуулсан.

Гэхдээ Баасан гарагийн өглөө Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банкны ерөнхийлөгч Жон Уильямсын хийсэн мэдэгдэл энэ байр суурийг өөрчлөв. Тэрээр ойрын хугацаанд хүү буурах боломжтой гэсэн дохио өгсөн нь зах зээлийн уур амьсгалыг эерэг болгож, хувьцааны зах зээлд итгэл нэмэхэд нөлөөлсөн байна. CME Group-ийн тооцооллоор бол ХНС ирэх уулзалтаараа хүүг бууруулах магадлал 70% орчим болсон байна. Энэ нь яг 1 долоо хоногийн өмнөх 44%-ийн таамгаас эрс өссөн үзүүлэлт юм.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.11.17 – 11.23

ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАЛТТАЙ БАЙЛАА.

Өнгөрсөн долоо хоногт Хятадын хөрөнгийн биржүүд Уолл стритийн уналтыг даган нийтээрээ суларсан үзүүлэлттэй гарлаа. Хиймэл оюун ухаантай холбоотой хувьцаануудын үнэлгээ хэт өндөр байна гэсэн болгоомжлол хөрөнгө оруулагчдын эрсдэл авах хүсэлтийг бууруулжээ.

CSI 300 долоо хоногийн турш 3.77%-иар буурсан бол Шанхайн нийлмэл индекс 3.90%-иар унав. Харин Хонг Конгийн гол индекс Hang Seng илүү их унан, 5.09%-иар буурсан байна. Сонирхолтой нь, уг индекс энэ оны 11-р сарын эхээр Хятадын технологийн хөгжилд хүлээж буй өөдрөг хүлээлтийн нөлөөгөөр сүүлийн 4 жилд хамгийн өндөр түвшинд хүрээд байсан юм.

Nvidia-н тайлан сайн гарснаар Азийн нилүүлэгч компаниудын хувьцаа өслөө

Nvidia тайлан таамгийг давж, 4-р улирлын борлуулалтын төлөвийг хүлээлтээс маш өндөр гаргасны дараа Азийн чип үйлдвэрлэгчдийн хувьцаа огцом өсөв. SK Hynix ойролцоогоор 4% өсөв. Nvidia-ийн AI-д ашиглагддаг өндөр хурдны санах ойн хамгийн том нилүүлэгч. Samsung Electronics 4% орчим өссөн. Nvidia-д санах ой нийлүүлдэг, SK Hynix-тай HBM сегментэд өрсөлдөж байна. Мөн дэлхийн хамгийн том гэрээт чип үйлдвэрлэгч TSMC нь, Nvidia-гийн чип дизайныг ихэнхийг үйлдвэрлэдэг.

Японы технологийн аварга SoftBank бараг 7% өсөв. Хэдий тус компани Nvidia-ийн хувьцааны эзэмшлээ саяхан зарсан ч:

- SoftBank нь ARM компанийн олонхийг эзэмшдэг (Nvidia ARM-ийн чип архитектурыг ашигладаг).
- Nvidia технологи дээр суурилсан олон AI төсөлд оролцдог, үүнд АНУ-д хэрэгжих 500 тэрбум долларын үнэлгээтэй Stargate дата төвийн төсөл багтана.

Хятад улс үл хөдлөх хөрөнгийн уналтыг зөөлрүүлэх шинэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна

Энэ долоо хоногт Хятадад албан ёсны ямар нэгэн гол эдийн засгийн үзүүлэлт гарсангүй. Харин бодлогын талд Bloomberg-ийн мэдээлснээр, Хятадын Засгийн газар эдийн засгийн хамгийн том эрсдэл болж буй орон сууцны зах зээлийн уналтыг зөөлрүүлэх шинэ арга хэмжээний багц боловсруулж эхэлжээ.

Засгийн газрын хэлэлцэж буй гол санаанууд нь:

- Анх удаа орон сууц худалдан авагчдад зориулж улсын хэмжээнд орон сууцны зээлийн хөнгөлөлт олгох,
- Орон сууцны зээлийн хүү, үндсэн төлбөр төлж буй иргэдийн орлогын албан татварын буцаалт нэмэх,
- Орон сууц худалдах, худалдан авахад төлдөг гүйлгээний шимтгэл, зардлыг бууруулах зэрэг байна.

Эдгээр бодлогын боломжит алхмуудын талаарх мэдээлэл гарч буй нь Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал 4 дэх жилдээ үргэлжилж, гуравдугаар улиралд бүр ч дордсон тухай статистик гараад удаагүйтэй холбоотой. Орон сууцны зах зээл энэ байдлаараа үргэлжилбэл Хятадын эдийн засгийн өсөлтөнд том дарамт үүсгэж, 2023 оны эхнээс үргэлжилж буй дэфляцын эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning November 17, 2025									
		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
		Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close